ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН, ТӨЛБӨР ТООЦОО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН БЭХХУЯГИЙН ОТГОНЗУЛЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. "Салбарын нягтлан бодох бүртгэл, тайлагналын нэгдсэн зохицуулалтыг хангах, хэрэгжилтийг хангана."** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** Төсвийн шууд захирагчийн 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгүүлнэ. | Тайлангийн тоо | 0 | 1 | Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан гаргах хуулийн хугацаа болоогүй. Тайлан гаргахтай холбогдуулан үүргийн сангийн тайлант хугацаанд санд төвлүүлэх мөнгөн хөрөнгө баталгажуулсан өглөг авлагын дэлгэрэнгүй бүртгэлийг санхүүгийн https://ctsystem.mn/ программд байгууллага тус бүрээр бүртгэл үүсгэн журналын бичилт хийн ажиллаж байна. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2024 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын албан шаардлагын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 02/913 тоот албан бичгийг цахимаар Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын https://pcsp.gov.mn/?page_id=5046 тооллогын системд бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2024 оны санхүүгийн тайланд тусгагдсан нийт дүн 16.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн бүртгэл хийн 2025 оны 04 дүгээр сарбн 24-нд илгээж баталгаажуулсан. | 2025.02.03-2025.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | **Дэд арга хэмжээ – 1.1.1:** Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж, Үндэсний аудитын газар, Сангийн яаманд тус тус хүргүүлж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгүүлнэ. | Тайлангийн тоо | 0 | 1 | 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан гаргах хуулийн хугацаа болоогүй байна. | 2025.02.03-2025.06.30 | 100% |
| **Зорилт 2. "Засгийн газрын тусгай сангийн төлбөр тооцоо, Төрийн сангийн тооцоо, яамны албан хаагчдын цалин, тэтгэмж, хөрөнгийн хөдөлгөөний бүртгэл хийх, хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлнэ."** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 2.1.** Шилэн дансны мэдээг цахим системд хуулийн хугацаанд оруулна. | Оруулсан мэдээний тоо | 0 | 15 | Хагас жилийн байдлаар Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан болон Өргөн нэтрүүлэг хөгжүүлэх сангийн нийт 15 мэдээллийг байршуулж шилэн дансын хууль тогтоомжид зааснаар хуулийн хугацаанд https://shilendans.gov.mn/ ил тод мэдээллэсэн. Харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас 2022-2024 төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө болон зарлагын мэдээллийг байгууллага тус бүрээр https://shilen.gov.mn/home цахим системд оруулсан. | 2025.02.03-2025.06.08 | 100% |
| 2. | **Арга хэмжээ 2.2.** Бүх нийтийн үйлчилгээний сангийн хөрөнгө төвлөрүүлэлт, тайлан баталгаажуулалт, төлбөр тооцоог хийж, бүртгэнэ. | Төвлөрүүлсэн орлогын хэмжээ | 5.1 тэрбум төгрөг | 2.2 тэрбум төгрөг | Харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудтай тайлан нийлэн баталгажуулж бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд 2.2 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө төвлөрүүлж батлагдсан төлөвлөгөө 130 хувийн гүйцэтгэлтэй байна. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд өр төлбөртэй байгаа 119 байгууллагатай нэг бүрчлэн холбогдож 27 байгууллагын 58.4 сая төгрөгийн авлагыг 100 хувь барагдуулсан. | 2025.02.03-2025.06.08 | 100% |
| | | | | | Харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч 66 аж ахуй нэгжтэй тооцоо нийлэн 4.3 тэрбум төгрөгийн тайланг баталгажуулсан. Үүнээс 2.2 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлж, УОО-с 5 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | **Дэд арга хэмжээ – 2.2.1:** Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн орлого төвлөрүүлэхтэй холбогдуулан харилцааа холбооны зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд, компаниудтай тайлан нийлж баталгаажуулах | Тусгай зөвшөөрлийн тоо | 0 | 50 | байгууллагын 2.1 тэрбум төгрөгийн тайланг баталгаажуулсан. Харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл эзэмшиж байх хугацаандаа Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.9 дэх заалт, Тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 354 дүгээр тогтоолоор батлагдсан " Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам"-ын 5.2, 5.4, 5.5 дахь хэсэгт тус тус заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд хөрөнгө төвлөрүүлэх үүрэгтэй 174 байгууллага руу 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 02/1086 тоот албан бичгээр хөрөнгө төвлөрүүлэх тухай мэдэгдэл хүргүүлсэн. Сителеком ХХК, Скайтел ХХК, Мобиком Корпораци ХХК, Жимобайл ХХК тус 4 байгууллагад 03/701, 02/924, 02/979, 02/1081 тоот албан бичгээр бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд өр төлбөргүй тухай тодорхойлолт гаргасан. | 2025.02.03-2025.06.08 | 100% |
| 4. | **Дэд арга хэмжээ – 2.2.2:** Тусгай сангийн жилийн төсвийн гүйцэтгэл гарган баталгаажуулах | Тайлангийн тоо | 0 | 6 | Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн төсвийн гүйцэтгэл 2025 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 0.6 хувийн гүйцэтгэлтэй БНҮҮС болон ӨНХСангийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гарган төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдээнд нэгтгэн оруулсан. | 2025.02.03-2025.06.08 | 100% |
| 5. | **Дэд арга хэмжээ – 2.2.3:** Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд, аж ахуй нэгжтэй тооцоо нийлж баталгаажуулсан мөнгөн дүнгээр нэхэмжлэх үүсгэн орлого төвлөрүүлэх | Төвлөрүүлсэн орлогын хэмжээ | 5.1 тэрбум төгрөг | 2.2 тэрбум төгрөг | Харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч 66 аж ахуй нэгжтэй тооцоо нийлэн баталгаажуулсан 2.2 тэрбум төгрөгийг https://ebarimt.mn/ цахим системээр нэхэмжлэх үүсгэн ажилласан. Баталгаажуулсан тайлангийн маягт болон нэхэмжлэхийн хамт байгууллага тус бүрт цахим шуудангаар хүргүүлсэн. Нэхэмжлэхийн дагуу төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн дүнгээр и-баримтыг хүлээн зөвшөөрч баталгаажуулан илгээсэн. | 2025.02.03-2025.06.08 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 3. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 3.1.** Нэгжид хуваарилагдсан баримт бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35.4 дүгээр заалтын хэрэгжилтийг хангах, хяналт тавих | Архивд хүлээлгэн өгсөн баримтын тоо | 0 | 3 | Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2009-2024 оны орлогын дэлгэрэнгүй мэдээлэл болон харилцаа холбооны тусгай зөвшөөрлийн үйлчилгээний ангилал бүрээр судалгааг гарган шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын мөрдөж 5 боть архивын баримт бүрдүүлж бэлтгэсэн. | 2025.02.03-2025.06.08 | 100% |
| 2. | **Арга хэмжээ 3.1.1:** Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон Авилгын эсрэг хууль тогтоомжийг мөрдөх, хэрэгжилтийг хангах | Мэдүүлгийн тоо | 0 | 1 | Хуулийн хугацаанд https://meduuleg.iaac.mn/AOS/Home системд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ бөглөж, баталгаажуулсан. | 2025.02.03-2025.02.15 | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Үүрэг даалгавар 1.** ТНБДаргын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/74 тоот албан тушаал | Үнэлгээний хорооны байгуулах тухай | | | Монгол Улсын Засгийн газар болон Дэлхийн банкны олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан Credit number 70-90-MN дугаартай зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Ухаалаг Засаг 2” төслийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 2.3.2.1-д заасан “Улсын бүртгэлийн цахим өгөгдлийн хадгалалт, хамгаалалт, нууцлал, аюулгүй байдлыг сайжруулах дэд бүтцийг бүтээх” төслийн тендерийн бичиг баримтыг 2025 оны 04 дүгээр сарын 11-ны өдөр үнэлгээний хороо хуралдан тендерийн баримт бичгийг боловсруулан ТНБД-аар батлуулсан ба тухайн тендерийг https://www.tender.gov.mn/ 2025 оны 04 дүгээр | 2025.03.25-2025.06.08 | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сарын 15-ны зарласан.Тус тендер зарласантай холбогдуулан оролцогч байгууллагаас 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр тодруулга авах хүсэлт ирсэн тул тодруулгын хариуг 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 02/1046 тоот албн бичгээр 5 байгууллагад цахим шуудан болон бичгээр хүргүүлсэн. Тендерийн баримт бичигт заасны дагуу тендер ирүүлэхээс өмнөх товч танилцуулга уулзалтыг 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 14 цагаас онлайнаар зохион байгуулж оролцогч нарт 2 дугтуйтай тендерт тендерийн баримт бичиг хэрхэн яаж ирүүлэх талаар чиглэл өгч ажилласан. Үнэлгээний хороо нь Улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт хамгаалалт, нууцлал аюулгүй байдлыг сайжруулах дэд бүтцийг бий болгох” ТББ батлах үнэлгээний хорооны хурал 2025 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн 16:00 цагт ЦХИХХЯ-ны 306 тоот өрөөнд танхим болон цахим хэлбэрээр, тендерийн тодруулга ирсэнтэй холбогдуулан үнэлгээний хорооны хурал 2025 оны 05 дугаар 05-ны өдрийн 10:00 цагт ЦХИХХЯ-ны 306 тоот өрөөнд танхим болон цахим хэлбэрээр явагдсан.Тендерийн бичиг баримтыг үнэлэх ажилтай холбогдуулан 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 14:00 цагт цахимаар тус тус хуралдаж ажилласан.<br>https://www.tender.gov.mn/ 2025 оны 04 дүгээр сарын 15-ны зарласан тенднерийг 2025 оны 05 сарын 15-ны өдрийн 11 цаг 30 минутанд нээж тендерт оролцогчийн материалыг хүлээн авсан.Тус тендерт 2 байгууллага тендерийн материал ирүүлсэн ба тендерийг үнэлэх ажил эхэлсэн байна. | | |
| | | | | | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад батлагдаж, эрх шилжсэн XX.3.1 Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | **Үүрэг даалгавар 2**<br>Үндэсний дата төв УТҮГазрын захиралын тушаал 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/35 тушаал | Үнэлгээний хорооны байгуулах тухай | | | /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг үохион байгуулах үнэлгээний хороон гишүүнээр орж ажилласан. Тус үнэлгээний хороо нь хуралдаж ТББ-г батлуулж https://user.tender.gov.mn/ цахим системд 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр урилга нийлтэлсэн.Тус тендерийн үнэлгээний хорооны хурал нь Тодруулга ирсэнтэй холбогдуулан 2025 оны 04 дүгээр сарын 24- ний өдөр цахим хэлбэрээр, Монополын эсрэг газраас түдгэлзүүлэх албан бичиг ирүүлсэн тул, өөрчлөлтийн хүсэлт гаргасан төлөвт шилжүүлсэнтэй холбогдуулан 2025 оны 04 дүгээр сарын 29- ний өдрийн 11:00 цагаас хурал Центрум оффис 404 тоот зохион байгуулагдсан. Монополын эсрэг газарт хариу хүргүүлэх тухай үнэлгээний хорооны хурал 2025 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 17:00 цагт цахимаар, Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөрөөмж нийлүүлэх багцтай тендерийн сонгон шалгаруулалтын үнэлгээ хийх хурлыг 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 17:00 цагаас цахимаар, тендерийн сонгон шалгаруулалтын үнэлгээ хийх хурлыг 2025 оны 05 дугаар сарын 20 -ний өдрийн 15:00 цагт танхим,<br>Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөрөөмж нийлүүлэх багцтай тендерийн үнэлгээний хорооны хуралд 2025 оны 06 дугаар сарын 03 -ний өдрийн 16:30 цагаас тус тус үнэлгээний хорооны 7 хуралд цахим болон танхимаар зохион байгуулагдсан хурлуудад саналын эрхтэй оролцож ажиллсан. | 2025.03.27-2025.06.03 | 100% |
| 3. | **Үүрэг даалгавар 3.**<br>ТНБДаргын 2025 оны 06 дугаар сарын 05 А/190 тоот тушаал | Үнэлгээний хорооны | | | Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн платформыг хөгжүүлэх" ЦХИХХЯ/20250103112 дугаартай ажлын | 2025.06.05-2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах тухай | | | тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хорооны нарийн бичгээр ажиллах болсонтой холбогдуулан ажлын даалгаварын хүрээнд ТББ-г боловсруулж батлуулахаар 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 15:00 цагт үнэлгээний хорооны хурал зарласан. | | |
| 4. | **Үүрэг даалгавар 4.** Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын арилжааны банкны дансны үлдэгдэлийг сангийн яамтай тулган баталгаажуулах | Харьяа байгууллага | | | ТЕЗ -ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан гарахтай холбогдуулан ЦХИХХЯ, Үндэсний дата төв УТҮГ, РТҮС УТҮГ, Монгол шуудан ХК, Монголын цахилгаан холбоо ХК, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Мэдээлэл технолгийн үндэснийй парк ТӨҮГ тус байгууллагуудын арилжааны банкны нийт үлдэгдэл 14.5 тэрбум төгрөгийг үлдэгдэлийг харилцахийн төгрөгийн үлдэгдэл 5.4 тэрбум төгрөг, гадаад валютын харилцахын үлдэгдэл 9.1 тэрбум төгрөг арилжааны банкны тулгалт хийн сангийн яамны төрийн сангийн газрын ахлах мэргэжилтэн Ш.Санзайдоржоор баталгаажуулсан. | 2025.02.03-2025.06-10 | 100% |
| 5. | **Үүрэг даалгавар 5.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн | | | | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн буюу бүх нийтийр мод тарих өдрийн хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр Түргэний гол дагуух “Ногоон хэрэм” зурваст Бүх нийтээр тод тарих өдөрт идэвхтэй оролцсон.<br>2025 оны 05 дугээр сарын 27-өөс 2025 оны 6 дугаар сарын 06-ний өдрүүдэд зохион байгуулсан “ICT спорт 2025” арга хэмжээнд идэвхтэй оролцлоо. | 2025.05.10-2025.06.06 | 100% |

**Зорилт 4. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг ур чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлнэ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Арга хэмжээ 4.1**<br>Мэдээлэл технологийн чиглэлийн 14 төрлийн цахим хичээл судлах /surgalt.gov.mn/ | Хамрагдсан сургалтын тоо | | 4 | Төсвийн хөрөнгө оруулалт,<br>Монгол бичгийн хичээл 2 дугаар шат,<br>Дижитал мэдээлэл,<br>Мэдээллийн аюулгүй байдал, ERP системийн тухай ерөнхий мэдлэг олгох сургалтад https://surgalt.gov.mn/ онлайнаар хамрагдсан. | 2025.02.03-2025.06.08 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Төрийн захиргааны удирдлагын газрын
Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтсийн
Засгийн газрын тусгай сан, төлбөр
тооцоо хариуцсан мэргэжилтэн

Б.Отгонзул / .......................... /

2025 оны 06 дугаар сарын 09